

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянтал сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2026/002/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Говьсүмбэр аймаг 2026 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179 Цахим хаяг: <a href="mailto:sarantuyab@audit.gov.mn">sarantuyab@audit.gov.mn</a> Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: <a href="mailto:nananbayarg@audit.gov.mn">nananbayarg@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Б.Анхтуяа Цахим хаяг: <a href="mailto:ankhtuyab@audit.gov.mn">ankhtuyab@audit.gov.mn</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



### ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: govsumber@audit.gov.mn

2026.03.25 № 56  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЯНТАЛ  
СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН  
ЗАХИРАГЧ Э.БАТТУЛГА ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагуудад дараах материаллаг хэмжээний зөрчлүүд илэрсэн байна. Тухайлбал:

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан 5 байгууллагын санхүүгийн нийт зөрчил 42.4 сая төгрөг бөгөөд бидний тогтоосон 19.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн барьцаа данстай холбоотой нийт 11.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 15 дугаар зүйлийн 15.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2.5, Засгийн газрын 2017 оны 170 дугаар

4226050255

тогтоолоор батлагдсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 3 дугаар зүйлийн 3.10 дахь заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>820,337.51</b>	<b>1,107,761.85</b>
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	427,356.62	590,582.19
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	149,822.46	235,105.41
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	218.67	218.67
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	216,012.26	258,043.09
6	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	26,927.5	23,812.5
<b>7</b>	<b>1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>2,729,831.09</b>	<b>7,129,457.4</b>
8	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	2,729,831.09	7,129,457.4
9	1.2.2.02 Биет хөрөнгө		2,443,581.09	6,843,128.9
10	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	286,250	286,328.5
<b>11</b>	<b>1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>		<b>3,550,168.6</b>	<b>8,237,219.26</b>
12	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		32,910.86	57,338.5
13	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		32,910.86	57,338.5
14	2.1.1.03 Өглөг		32,910.86	57,338.5
<b>15</b>	<b>2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>3,517,257.75</b>	<b>8,179,880.76</b>
16	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		3,517,257.75	8,179,880.76
17	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		756,504.79	756,504.79
18	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		2,015,186.56	6,677,809.57
19	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		745,566.4	745,566.4
<b>20</b>	<b>2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>		<b>3,550,168.6</b>	<b>8,237,219.26</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>		<b>3,162,853.25</b>	<b>7,096,976.36</b>
2	<b>1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>		<b>392,492.99</b>	<b>501,247.21</b>
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		266,946.85	396,090.44
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		277,113.67	396,090.44
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-10,166.82	0.0
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		43,474.91	29,791.43
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		82,071.23	75,365.35
8	<b>1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1а, 1б</b>	<b>467,708.76</b>	<b>6,595,729.15</b>
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	1,528,169.2
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,302,651.5	0.0
11	<b>1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2а, 2б</b>	<b>1,976,865.2</b>	<b>2,402,749.5</b>
12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		1,976,865.2	2,402,749.5
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,946,169.2	2,377,324.09
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		708,223.55	872,880.12
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		86,702.88	107,731.03
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		474,230.66	492,838.41
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		139,939.91	134,358.76
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		17,800	95,481.7
19	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		14,076.0	14,722.0
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		57,912.63	29,948.11

21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		447,283.58	629,363.96
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		30,696	25,425.41
<b>23</b>	<b>1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		<b>1,185,988.05</b>	<b>4,694,226.86</b>
24	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		0.0	71.25
25	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		0.0	-71.25
<b>26</b>	<b>1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>		<b>1,185,988.05</b>	<b>4,694,155.61</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,761,331.1</b>	<b>2,428,570.02</b>
<b>2</b>	<b>1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>392,492.99</b>	<b>501,247.21</b>
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	266,946.85	396,090.44
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-10,166.82	0.0
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	43,474.91	29,791.43
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	82,071.23	75,365.35
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	9,591.07	12,969
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	5,820.76	41,516.35
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	66,659.4	20,880
<b>10</b>	<b>1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>66,186.61</b>	<b>1,927,322.81</b>
11	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	66,186.61	33,903.61
12	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,528,169.2
13	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	365,250
14	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,302,651.5	0.0
<b>15</b>	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,666,907.39</b>	<b>1,827,265.07</b>
16	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,666,907.39	1,827,265.07
17	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,581,577.05	1,784,308.36
18	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	727,045.33	872,825.73

19	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,606.69	108,012.77
20	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	474,230.66	492,910.01
21	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	46,510.14	29,262.22
22	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	250	0.0
23	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	35,433.7	116,314.73
24	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	14,076	13,872
25	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	76,857.03	41,501.98
26	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	119,567.5	109,608.92
27	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	85,330.33	42,956.71
28	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,094,423.71	601,304.95
29	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,017,366.46	308,203.88
30	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,017,366.46	308,203.88
31	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	1,017,366.46	308,203.88
32	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,017,366.46	-308,203.88
33	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,776	129,875.5
34	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-1,776	-129,875.5
35	<b>1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>75,281.25</b>	<b>163,225.57</b>
36	<b>1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>352,075.37</b>	<b>427,356.62</b>
37	<b>1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>427,356.62</b>	<b>590,582.19</b>

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,330,621.63		2,330,621.63
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	648.06		648.06
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,331,269.69		2,331,269.69
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	1,185,988.05		1,185,988.05
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,517,257.75		3,517,257.75
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,517,257.75		3,517,257.75
7	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-31,532.6		-31,532.6
8	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,485,725.15		3,485,725.15
9	1.7 Тайлант үеийн үр дүн	4,694,155.61		4,694,155.61
10	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	8,179,880.76		8,179,880.76

**2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>2,270,016.1</b>	<b>2,426,550.82</b>
2	3.1.01.1.1 Татварын орлого	337,116.1	501,247.21
22	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,932,900	1,925,303.61
32	<b>3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,646,979.99</b>	<b>2,262,530.01</b>
33	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	2,087,197.69	1,820,244
34	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,995,060	1,777,287.29
35	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	984,205	872,825.73
40	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,395	108,012.77

46	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	516,860	492,910.01
50	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	30,300	28,422.22
56	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	121,500	119,835.53
60	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	14,500	13,872
61	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	14,500	13,872
62	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	64,100	41,501.98
69	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	139,200	99,907.05
72	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,137.69	42,956.71
73	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	67,337.69	22,641.3
79	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	399,235	312,410.51
81	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	160,547.3	129,875.5
<b>83</b>	<b>3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>-376,963.89</b>	<b>164,020.82</b>
<b>84</b>	<b>3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>-376,963.89</b>	<b>-164,020.82</b>
<b>85</b>	<b>3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	<b>-376,963.89</b>	<b>-164,020.82</b>
86	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	376,963.89
87	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	540,984.7
88	6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	50	48
91	6.2 АЖИЛЛАГСАДЫН ТОО	24	23
92	6.2.01 Удирдах ажилтан	7	7
93	6.2.02 Гүйцэтгэх ажилтан	12	12
94	6.2.03 Үйлчлэх ажилтан	3	3
95	6.2.04 Гэрээт ажилтан	2	1

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,019.2
2	12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,019.2
3	122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	2,019.2
4	1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	2,019.2

5	12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	2,019.2
6	350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,179.2
7	350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	840.0
8	<b>II</b>	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,021.1</b>
9	21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	2,021.1
10	210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,021.1
11	2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	840.0
12	210406	1.1.1.2.1.1.4.6 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	840.0
13	2106	1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	1,179.2
14	210604	1.1.1.2.1.1.6.4 Урсгал засвар	1,179.2
15	2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	1.87
16	210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	1.87
17	<b>4</b>	<b>1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>-1.87</b>
18	<b>5</b>	<b>1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1.87</b>
19	<b>6</b>	<b>1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	<b>1.87</b>
20	9	2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

### **4.3.1 Харьяа байгууллагууд**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр караоке тэмцээн зохиож, одон медалиар шагнагдсан ажилтанд хуульд заагаагүй урамшуулал олгосон /Баянтал сумын ЗДТГ-1.3 сая/

**4.3.2** ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байна.

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

**4.4.1.1** ТТЗ-ийн тайланд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд "Төсөв гүйцэтгэл" цэст Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 1 удаа хоцроож мэдээлсэн, 11 дүгээр сард мэдээлээгүй, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт 2 удаа, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөөг 1 удаа, "Бусад" цэст Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан 1 удаа нийт 5 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн, өмнөх аудитаар илэрсэн зөрчил давтагдсан, сумын нэгтгэлд хамрагдсан байгууллагуудын Шилэн дансны зөрчил буураагүй нэмэгдсэн.

Энэ нь Засгийн газрын 2014 оны 326, 2019 оны 88 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив”-ын 1 дүгээр зүйлийн 1.1.3-т “орон нутгийн хөгжлийн сан, тусгай зориулалтын шилжүүлэг, сумын нэгдсэн төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг хийж орон нутгийн төсвийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын нягтлан бодогч болон төрийн сангийн мэргэжилтнийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах; (Энэ дэд заалтыг Засгийн газрын 2019 оны 88 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)”, 1.1.10-д “харьяа байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хүлээн авч шалгах, залруулга хийх, нэгтгэх, дүн шинжилгээ хийх (Энэ дэд заалтыг Засгийн газрын 2019 оны 88 дугаар тогтоолоор нэмсэн)” гэсэн заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг давтан гаргасан, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй санхүүгийн албаны даргад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### **4.4.1.2 Харьяа байгууллагууд**

Харьяа төсвийн байгууллагуудад Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад нийт 666.9 сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн байна.

- Нийт 25.7 сая төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй ба 82.3 сая төгрөгийн 5 гүйлгээ хоцроож мэдээлсэн ба хуулийн хэрэгжилтийн мэдээлэл 83.9 хувьтай, хугацаа хоцролт 88.2 хувьтай мэдээллийг тогтоосон цаг хугацаанд үнэн зөв байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргасан /Баянтал сумын ИТХ/

- Шилэн дансны цахим хуудсанд тайлант онд нийт 1,774.5 сая төгрөгийн 106 гүйлгээ болон шийдвэрийг мэдээлэхээс 254.2 сая төгрөгийн 23 гүйлгээ болон шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Шилэн дансны мэдээлэлт 100 хувь боловч хугацаа хоцролт 76.0 хувьтай мэдээллийг тогтоосон цаг хугацаанд үнэн зөв байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргасан /Баянтал сумын ЗДТГ/
- Нийт 911.1 сая төгрөгийн 36 гүйлгээ мэдээлэхээс 173.8 сая төгрөгийн 9 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Өмнөх аудитаар зөрчил арилгуулах албан шаардлага өгсөн боловч зөрчлийг давтан гаргасан. /Баянтал сумын ОНХС/
- Хөрөнгө зарцуулах 3 удаагийн 130.9 сая төгрөгийн шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн. Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан /Баянтал сумын ХХС/

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

**44.4.2.1** Төрийн сангийн төлбөр тооцооны журмыг баримтлаагүй, байгууллагуудын ажил гүйлгээг хянаж баталгаажуулахдаа анхан шатны баримтгүй, хувь хүний болон нярвын данс руу бэлэн мөнгө шилжүүлсэн, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.12.3-т “Төрийн сан нь энэ журмын 2.12.2-т заасан шаардлагыг хангасан төсвийн байгууллагын хүсэлтийг хянаж, ажлын 3 өдрийн дотор зарцуулах эрхийг олгоно”, 3 дугаар зүйлийн 3.4.10-т “Төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана” заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг давтан гаргасан, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй санхүүгийн албаны даргад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### **4.4.2.2 Харьяа байгууллагууд**

Харьяа төсвийн байгууллагуудад бусад хууль тогтоомжтой холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Тендерийн баталгаа хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, нягтлан бодогч нь анхан шатны баримтын бүрдэлгүй буюу бэлэн мөнгө гаргаж гүйлгээ хийдэг, мөн нярвын дансанд бэлэн мөнгө шилжүүлсэн, завсрын аудитаар баримтын бүрдэл хангах зөвлөмжийг өгсөн боловч бүрэн хэрэгжүүлээгүй, байгууллагад ашиглаж байгаа хөрөнгөө бүртгээгүй, бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан, санхүүгийн үйл ажиллагааг зөв зохистой удирдан зохион байгуулаагүй, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй, жил бүр алдаа зөрчлийг давтан гаргасан /Баянтал сумын ЗДТГ/

#### **5. Аудитын илрүүлэлт:**

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар залруулга хийгээгүй байна.

Аудитаар нийт 12.7 сая төгрөгийн 4 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 3.0 сая төгрөгийн 1 зөрчилд 1 төлбөрийн акт, 9.7 сая төгрөгийн 2 зөвлөмж, 1 сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн байна.

### **Харьяа байгууллагууд**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн, нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад “Өөрчлөлтгүй” дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 768.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 69.4 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 1.3 сая төгрөгийн 1 зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 30.5 сая төгрөгийн 6 зөрчилд 6 албан шаардлага, 666.9 сая төгрөгийн 5 зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн байна. /Хавсралт 1-ээс үзнэ үү/

Өмнөх онтой харьцуулахад харьяа байгууллагуудын нийт зөрчлийн дүн 7 дахин өссөн ба үүнээс: залруулга 3 дахин, сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага 100% тус тус өссөн, төлбөрийн акт 94.7%, зөвлөмж 100% буурсан үзүүлэлттэй байна. Нийт зөрчлийн дүн өссөн нь Шилэн дансны тухай хууль болон бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил буураагүй, 652.4 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй байна.

Залруулагдаагүй нийт зөрчлийн 42.4 сая төгрөг нь аудитаар тогтоосон ерөнхий материаллаг байдлаас их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

## **5.1 Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага**

### **5.1.1 Төлбөрийн акт**

2023-2024 онд ОНХС-ийн санхүүжилтээр хийгдсэн "Баяр наадмын талбайг шинээр барих", "Баяр наадмын талбайг өргөтгөх нэмэлт ажил"-ын захиалагчийн хяналтын зардлыг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлээгүй боловч хэмнэлтэд төвлөрүүлээгүй, өөрсдөө хяналт тавьсан нэрийдлээр төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, 2.9 сая төгрөгийн шатахууны зардал гаргасан /Анхан шатны баримтууд нотлох баримтын шаардлага хангаагүй, үндэслэлгүй /

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2.5-д “төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх”, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.10-д “Захиалагч барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажил болон тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилт зэрэг холбогдох бусад баримт

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бичгийг барилгын ажил гүйцэтгэх төлөвлөгөө (график), гэрээнд заасны дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчидтой хамтран сар бүр хянан баталгаажуулна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн орлогод төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох, 2026.09.21-ний дотор төлбөрийн актыг барагдуулж хариу ирүүлэх

## **5.1.2 Албан шаардлага**

Байхгүй

## **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Барьцаа данстай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт: 2023-2024 онд ОНХС-ийн санхүүжилтээр хийгдсэн "Баяр наадмын талбайг шинээр барих" ажлын барьцаа 4.8 сая , "Баяр наадмын талбайг өргөтгөх нэмэлт ажил"-ын барьцаа 3.7 сая мянга, нийт 8.5 сая төгрөгийг 2024 онд барьцаа дансанд шилжүүлээгүйн улмаас 2025 оны ОНХС-ийн санхүүжилтээр хийгдэх төсөл арга хэмжээний жагсаалтад эх үүсвэр болгон оруулж батлуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2.5-д “өсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх”, 4.2.2.6-д “чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг гүйцэтгэл тус бүрээс, эсхүл эцсийн буюу бүрэн санхүүжилтээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43.6-д заасны дагуу суутган барьцаа хөрөнгийн дансанд байршуулах асуудлыг тухайн төсөл, арга хэмжээний гэрээний тусгай нөхцөлд тусгасан байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсөл, арга хэмжээний гэрээний тусгай нөхцөлд зааснаар тайлант онд багтаан барьцаа хөрөнгийг барьцаа дансанд байршуулах, он дамжин шилжүүлэхгүй байх

### **2. Нэмэлт төсөвтэй холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт: Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг зөрчиж, шаардлага хангаагүй нэмэлт төсөвт зарцуулах эрх олгосон /Баянтал сумын ИТХ нэмэлт санхүүжилт орлого 1.2 сая / байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 47 дүгээр зүйлийн 47.1-д “Төсвийн захирагч нь дараах нэмэлт төсвийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болно”, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 2 дугаар зүйлийн 2.12.3-д “Төрийн сан нь энэ журмын 2.12.2-т заасан шаардлагыг хангасан төсвийн

байгууллагын хүсэлтийг хянаж, ажлын 3 өдрийн дотор зарцуулах эрхийг олгоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хууль, Төрийн сангийн үйл ажиллагааны журамд заасан шаардлага хангасан нэмэлт төсвийн хүсэлтэд зарцуулах эрх олгох

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баянтал сумын Засаг дарга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Баянтал сумын ИТХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Баянтал сумын ЗДТГ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Баянтал сумын ОНХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Баянтал сумын ХХС	1	69.4	-	-	1	69.4	1	69.4	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>69.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>69.4</b>	<b>1</b>	<b>69.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Баянтал сумын Засаг дарга	3	12.7	1	2.9			2	9.8	1	1		
Баянтал сумын ИТХ									1	1		
Баянтал сумын ЗДТГ	3	10.7			3	10.7			1	1		
Баянтал сумын ОНХС	2	19.0			2	19.0			1	1		

Баянтал сумын ХХС									1	1		
<b>Нийт</b>	<b>8</b>	<b>42.4</b>	<b>1</b>	<b>2.9</b>	<b>5</b>	<b>29.7</b>	<b>2</b>	<b>9.8</b>	<b>5</b>	<b>5</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Баянтал сумын Засаг дарга	1	0.0			1	0.0		
Баянтал сумын ИТХ	1	108.0			1	108.0		
Баянтал сумын ЗДТГ	1	254.2			1	254.2		
Баянтал сумын ОНХС	1	173.8			1	173.8		
Баянтал сумын ХХС	1	130.9			1	130.9		
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>666.9</b>			<b>5</b>	<b>666.9</b>		
<b>Бусад зөрчил</b>								
Баянтал сумын Засаг дарга								
Баянтал сумын ИТХ								
Баянтал сумын ЗДТГ	2	2.1	1	1.3	1	0.8		
Баянтал сумын ОНХС								
Баянтал сумын ХХС								
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>2.1</b>	<b>1</b>	<b>1.3</b>	<b>1</b>	<b>0.8</b>		
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>669.0</b>	<b>1</b>	<b>1.3</b>	<b>6</b>	<b>667.7</b>		

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	2	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС	2		3					
4	ТТЗ	1	1				1		
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>5</b>	<b>2</b>	<b>3</b>		<b>1</b>	<b>1</b>		

